



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.24 № 03/17 ЧАГ-САГ/2014/63/СТГА-ТӨЧГ

Зөрчлийг арилгуулах тухай

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дуусгавар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар тус байгууллага ХХОАТ-ыг ногдуулж, төсөвт төвлөрүүлээгүй дараах зөрчил илэрлээ.


“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ -аас 2013 оны 07 дугаар сарын 08-нд Захиргаа удирдлагын хэлтсийн даргаар ажиллаж байсан Ц.Сүхбаатарт АНУ-д суралцах магистрийн сургалтын төлбөрт 56,591,400.00 төгрөгийг олгосон бөгөөд ногдох ХХОАТ болох 5,659,140.00 төгрөгийг суутгаагүй, харьяалагдах татварын хэлтэст тайлагнаагүй, санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д заасан “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх”, 7 дугаар зүйлийн 7.4-т “Аж ахуй нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ”, 7.7-т “анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалт болон ХХОАТатварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9-т заасан “шууд бус орлого”-оос, 22 дугаар зүйлийн 22.1.4-т “шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр” гэж заасныг дагуу, 23 дугаар зүйлийн 23.1-т “энэ хуулийн 17-19 дүгээр зүйл, 20.1.2-20.1.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна” заалтаар суутгалыг хийж мөн 26 дугаар зүйлийн 26.3-т “Суутгагч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 26.1.6-д зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ” заалтыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцат илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудитор 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсгийн заалтыг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

Ц.Сүхбаатараас 5,659,140.00 төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутган авч, Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн Нийслэлийн төрийн сан банкны 200000993 дугаар тоот дансанд 2014 оны 4 дүгээр сарын 15-ны дотор төвлөрүүлэх, биелэлтийг 2014 оны 04 дүгээр сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ийн, Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Г.Түвшинтөгсд даалгав.

ШИНЖЭЭЧ



Н.НЯМДАВАА